



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Шүүхийн тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СБА-2023/03/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Баруун-Урт сум 2023 он	Дарга, тэргүүлэх аудитор: М.Нарантуяа Утас: 70518396 Аудитын менежер: Г.Даваа Утас: 70512123 Аудитор: А.Мөнхцэцэг Утас: 70512127
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	11
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12
4. АУДИТЫН ТАЙЛАН	14
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал.....	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
4.5.1 Завсрын аудитын талаар.....	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	16
5.1 Төлбөрийн акт	16
5.2 Албан шаардлага.....	17
5.3 Зөвлөмж	
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	17

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

**СҮХБААТАР АЙМГИЙН ШҮҮХИЙН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Ц.ГАНХУЯГ
ТАНАА**

2023.02.24 № 68

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар дахь Шүүхийн тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сүхбаатар дахь Шүүхийн тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд машины зогсоол, хашаа барих ажил хийгдсэн боловч худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны тухай хуульд нийцэхгүй байна.

Аудитын гол асуудал

Төсвийн хөрөнгийн зарцуулагдаагүй үлдэгдлийг ахмадын санд төвлөрүүлсэн нь Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2017 оны 197 тоот тогтоолын холбогдох заалтуудтай нийцээгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Сүхбаатар аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 36 арга хэмжээг төлөвлөн, хэрэгжилтийг "Дүүрэн хангалттай" үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>19,235,481.20</u>	<u>36,284,063.22</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	22,262,214.93
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	22,262,214.93
3121	Төгрөг	00.00	22,262,214.93
31211	Төрийн сангийн харилцах	00.00	22,262,214.93
35	БАРАА МАТЕРИАЛ	19,235,481.20	14,021,848.29
354	Хангамжийн материал	17,717,479.50	12,492,987.00
35410	Бичиг хэргийн материал	1,428,450.00	2,439,698.00
35420	Аж ахуйн материал	15,799,029.50	9,563,289.00
35450	Барилгын засварын материал	490,000.00	490,000.00
35600	Мал амьтад	1,518,001.70	1,528,861.29
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>721,293,510.32</u>	<u>839,859,194.18</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	721,293,510.32	839,859,194.18
392	Биет хөрөнгө	661,673,510.32	779,744,194.20
39201	Барилга, байгууламж, орон сууц	480,665,000.00	576,671,158.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-26,252,442.36	-35,003,256.48
39203	Авто-тээврийн хэрэгсэл	127,790,400.00	127,790,400.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-12,365,597.94	-29,286,660.42
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	111,496,401.50	109,949,315.30
39206	Хуримтлагдсан элэгдэл	-42,321,449.83	-56,466,341.31
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	79,172,124.37	66,952,514.02
39208	Хуримтлагдсан элэгдэл	-61,200,156.54	-45,424,265.67
39214	Бусад үндсэн хөрөнгө	6,138,868.20	66,394,568.20
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,825,669.08	-2,399,269.44
39217	Ном	376,032.00	566,032.00
393	Биет бус хөрөнгө	59,620,000.00	60,114,999.98
39301	Програм хангамж	1,550,000.00	1,550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-550,000.00	-55,000.02
39305	Газар	58,620.000	58,620.000
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>740,528,991.52</u>	<u>876,143,257.40</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>740,528,991.52</u>	<u>876,143,257.40</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	740,528,991.52	876,143,257.40
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	517,169,325.00	517,169,325.00
51101	Өмч: - төрийн	517,169,325.00	517,169,325.00
512	Хуримтлагдсан үр дүн	-411,321,550.86	-275,707,284.98
51210	Өмнөх үеийн үр дүн	-500,140,539.65	-411,321,550.86
51220	Тайлант үеийн үр дүн	88,818,988.79	135,614,265.88
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	634,681,217.38	634,681,217.38
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>740,528,991.52</u>	<u>876,143,257.40</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,234,095,620.00	1,628,619,408.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	126,398,220.00	119,195,108.00
120	Нийтлэг татварын бус орлого	126,398,220.00	119,195,108.00
120009	Бусад орлого	726,000.00	8,031,000.00
120017	Үнэ төлбөргүй орлого Үндсэн хөрөнгө	125,306,764.00	106,956,938.00
120018	Үнэ төлбөргүй орлого Бараа материал	365,456.00	4,207,170.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,107,697,400.00	1,509,424,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,107,697,400.00	1,489,424,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,107,697,400.00	1,489,424,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	20,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	20,000,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,145,276,631.21	1,493,005,142.12
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,145,276,631.21	1,493,005,142.12
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,140,327,032.10	1,461,542,229.55
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	851,493,476.89	1,079,722,685.07
210101	Үндсэн цалин	657,133,804.23	745,027,356.00
210102	Нэмэгдэл	141,380,405.51	270,734,138.03
210103	Унаа хоолны хөнгөлөлт	24,153,048.15	25,959,245.39
210104	Урамшуулал	28,826,219.00	38,001,945.65
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	107,492,200.00	136,083,217.43
210201	Тэтгэврийн даатгал	76,644,300.00	91,745,737.84
210202	Тэтгэмжийн даатгал	7,712,000.00	12,322,607.16
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,409,600.00	8,618,090.53
210204	Ажилгүйдлийн даатгал	2,567,959.86	2,126,980.25
210205	Эрүүл мэндийн даатгал	14,158,340.14	21,269,801.65
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,337,384.00	71,500,000.00
210301	Гэрэл, цахилгаан	4,766,734.00	5,000,000.00
210302	Түлш, халаалт	37,095,050.00	61,000,000.00
210303	Цэвэр, бохир ус	3,475,600.00	5,500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	66,576,845.53	80,636,302.91
210401	Бичиг хэрэг	14,515,856.00	19,503,602.00
210402	Тээвэр, шатахуун	17,651,997.00	26,276,097.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,439,787.00	8,453,080.00
210404	Ном, хэвлэл	00.00	1,000,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	590,000.00	472,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	24,444,231.50	24,070,883.50
210408	Бараа материал акталсны зардал	934,974.03	860,140.41
2105	Нормативт зардал	00.00	800,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	800,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,721,133.00	15,057,290.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	947,919.00	279,090.00
210604	Урсгал засвар	15,773,214.00	14,778,200.00
2107	Томилолт, зочны зардал	8,609,400.00	8,294,400.00
210702	Дотоод албан томилолт	8,609,400.00	8,294,400.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,622,450.00	10,241,380.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,842,750.00	7,680,880.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	615,200.00	1,738,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	57,300.00	109,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,050,000.00	300,000.00
210807	Газрын төлбөр	35,200.00	390,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	37,474,142.68	59,206,954.14
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	37,474,142.68	59,206,954.14
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,949,599.11	31,462,912.57
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,000,000.00	29,205,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	22,180,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,000,000.00	7,025,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,949,599.11	2,257,612.57
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,949,599.11	2,257,612.57
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	88,818,988.79	135,614,265.88
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	88,818,988.79	135,614,265.88

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,107,697,400.00	1,536,711,514.93
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	27,287,214.93
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	27,287,214.93
120009	Бусад орлого	00.00	27,287,214.93
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,107,697,400.00	1,509,424,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,107,697,400.00	1,489,424,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,107,697,400.00	1,489,424,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	20,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	20,000,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,099,285,400.00	1,450,793,600.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,099,285,400.00	1,450,793,600.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,094,335,800.89	1,419,330,687.43
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	851,493,476.89	1,100,009,900.00
210101	Үндсэн цалин	657,133,804.23	765,314,570.93
210102	Нэмэгдэл	141,380,405.51	270,734,138.03
210103	Унаа хоолны хөнгөлөлт	24,153,048.15	25,959,245.39
210104	Урамшуулал	28,826,219.00	38,001,945.65
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	107,492,200.00	136,083,217.43
210201	Тэтгэврийн даатгал	76,644,300.00	91,745,737.84
210202	Тэтгэмжийн даатгал	7,712,000.00	12,322,607.16
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,409,600.00	8,618,090.53

210204	Ажилгүйдлийн даатгал	2,567,959.86	2,126,980.25
210205	Эрүүл мэндийн даатгал	14,158,340.14	21,269,801.65
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,337,384.00	71,500,000.00
210301	Гэрэл, цахилгаан	4,766,734.00	5,000,000.00
210302	Түлш, халаалт	37,095,050.00	61,000,000.00
210303	Цэвэр, бохир ус	3,475,600.00	5,500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	50,779,639.00	69,028,000.00
210401	Бичиг хэрэг	12,982,372.00	18,903,070.00
210402	Тээвэр, шатахуун	17,651,997.00	26,276,097.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,439,787.00	8,453,080.00
210404	Ном, хэвлэл	00.00	1,000,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	590,000.00	472,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,115,483.00	13,923,253.00
2105	Нормативт зардал	800,000.00	800,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800,000.00	800,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,201,251.00	16,373,790.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,082,237.00	1,595,590.00
210604	Урсгал засвар	14,119,014.00	14,778,200.00
2107	Томилолт, зочны зардал	8,609,400.00	8,294,400.00
210702	Дотоод албан томилолт	8,609,400.00	8,294,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,622,450.00	10,241,380.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,842,750.00	7,680,880.00
210803	Даатгалын үйлчилгээ	615,200.00	1,738,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	57,300.00	109,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,050,000.00	300,000.00
210807	Газрын төлбөр	35,200.00	390,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	7,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	7,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,949,599.11	31,462,912.57
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,000,000.00	29,205,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	22,180,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,000,000.00	7,025,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,949,599.11	2,257,612.57
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,949,599.11	2,257,612.57
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	8,412,000.00	85,917,914.93
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	8,412,000.00	63,655,700.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	8,412,000.00	63,655,700.00
2200	Дотоод эх үүсвэрээр	8,412,000.00	63,655,700.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	8,412,000.00	63,655,700.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-8,412,000.00	-63,655,700.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	22,262,214.93
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	22,262,214.93

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	517,169,325.00	634,681,217.38	-500,140,539.65	00.00	651,710,002.73
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	0	00.00	0
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	517,169,325.00	634,681,217.38	-500,140,539.65	00.00	651,710,002.73
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	88,818,988.79	00.00	88,818,988.79
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	517,169,325.00	634,681,217.38	-411,321,550.86	00.00	740,528,991.52
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	517,169,325.00	634,681,217.38	-411,321,550.86	00.00	740,528,991.52
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	517,169,325.00	634,681,217.38	-411,321,550.86	00.00	740,528,991.52
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	135,614,265.88	00.00	135,614,265.88
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	517,169,325.00	634,681,217.38	-275,707,284.98	00.00	876,143,257.40

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,489,424,300.00	1,487,166,687.43
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,489,424,300.00	1,487,166,687.43
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,465,244,000.00	1,462,986,387.43
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,100,009,900.00	1,100,009,900.00
210101	Үндсэн цалин	715,653,700.00	765,314,570.93
210102	Нэмэгдэл	334,236,200.00	270,734,138.03
210103	Унаа хоолны хөнгөлөлт	26,676,000.00	25,959,245.39
210104	Урамшуулал	23,444,000.00	38,001,945.65
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	137,501,200.00	136,083,217.43
210201	Тэтгэврийн даатгал	93,500,800.00	91,745,737.84
210202	Тэтгэмжийн даатгал	11,000,100.00	12,322,607.16
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,800,100.00	8,618,090.53
210204	Ажилгүйдлийн даатгал	2,200,000.00	2,126,980.25
210205	Эрүүл мэндийн даатгал	22,000,200.00	21,269,801.65
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	71,500,000.00	71,500,000.00
210301	Гэрэл, цахилгаан	5,000,000.00	5,000,000.00
210302	Түлш, халаалт	61,000,000.00	61,000,000.00
210303	Цэвэр, бохир ус	5,500,000.00	5,500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	73,128,000.00	73,128,000.00
210401	Бичиг хэрэг	20,500,000.00	18,903,070.00
210402	Тээвэр, шатахуун	23,392,000.00	29,276,097.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,636,000.00	8,453,080.00
210404	Ном, хэвлэл	1,000,000.00	1,000,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	600,000.00	472,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16,000,000.00	15,023,253.00
2105	Нормативт зардал	800,000.00	800,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800,000.00	800,000.00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	54,200,000.00	54,188,190.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,000,000.00	4,995,590.00
210604	Урсгал засвар	49,200,000.00	49,192,600.00
2107	Томилолт, зочны зардал	8,294,400.00	8,294,400.00
210702	Дотоод албан томилолт	8,294,400.00	8,294,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,810,500.00	11,982,680.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,250,000.00	9,422,180.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,738,600.00	1,738,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	109,400.00	109,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	300,000.00	300,000.00
210807	Газрын төлбөр	390,500.00	390,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7000000.00	7000000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,000,000.00	7,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24180300.00	24180300.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	24,180,300.00	24,180,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	22,180,300.00	22,180,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	2,000,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,489,424,300.00	1,487,166,687.43
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,489,424,300.00	1,487,166,687.43
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,489,424,300.00	1,487,166,687.43
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	22,262,214.93

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	20,000,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	20,000,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	20,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,840,000.00
210604	Урсгал засвар	9,840,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,160,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,160,000.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	20,000,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	20,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	20,000,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сүхбаатар аймаг дахь Шүүхийн тамгын газар шүүн таслах ажиллагааг тасралтгүй хэвийн явуулах нөхцөлөөр хангах, шүүхийн захиргааны удирдлагыг үр нөлөөтэй хэрэгжүүлэх үүднээс дотоод хяналтыг сайжруулахад анхаарахын зэрэгцээ шүүхийн үйлчилгээг олон нийтэд хүртээмжтэй хүргэх, зорилтод бүлгийн иргэдэд зориулсан үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, шүүхийн архивыг цахимжуулах зорилтуудыг дэвшүүлэн үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэн ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сүхбаатар аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 135,614.3 мянган төгрөгөөр буюу 18.3 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	22,262.0	22,262.0
Бараа материал	19,235.4	14,021.8	(5,213.6)
Үндсэн хөрөнгө	721,293.5	839,859.2	118,565.6
Нийт хөрөнгө	740,528.9	876,143.2	135,614.3
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	740,528.9	876,143.2	135,614.3
	740,528.9	876,143.2	135,614.3

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 22,262.0 мянган төгрөг болж өссөн нь цалингийн зардлаас зарцуулагдаагүй үлдэгдлийг ахмадын сангийн дансанд төвлөрүүлсэн нь нөлөөлжээ.
- Бараа материалын дансны үлдэгдэл 14,021.8 мянган төгрөг болж 5,213.6 мянган төгрөгөөр буурсан байна.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 839,859.2 мянган төгрөг болж 118,565.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. ШЕЗ-д тендер зарлагдан үнэ төлбөргүй 96,006.2 мянган төгрөгийн шугам сүлжээ тавигдсан, 4,564.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 6,196.0 мянган төгрөгийн тавилга нийлүүлсэн, төсвийн хөрөнгөөр 3,400.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан, 60,255.7 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил / хашаа, авто машины зогсоол/ баригдсан, дахин үнэлсэн 7,160.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл, үнэ төлбөргүйгээр нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.
- Сүхбаатар аймаг дахь Шүүхийн тамгын газрын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 394,523.8 мянган төгрөг буюу 31.9 хувиар нэмэгдсэн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урсгал санхүүжилт, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого, бусад орлогын данс байна. Тодруулбал тайланд онд Санхүүжилт 381,726.9 мянган төгрөг, ЗДНС дэмжлэг 20,000.0 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан материал 3,841.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,428,287.5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,428,287.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 149,076.7 мянган төгрөгөөр бууруулж, 1,279,210.8 мянган төгрөгөөр баталсан байна. Төсвийн тодотголоор тус байгууллагын өөрчлөн 207,955.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхэд 1,489,424.3 мянган төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,489,424.3 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлого 2,257.6 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,487,166.7 мянган төгрөг буюу 99.8 хувьтай зарцуулсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/ мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80101- Үндсэн үйл ажиллагаа	1,462,744.0	1,461,307.5	1,436.5	99.9%
2	80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал дэмжлэг	24,180.3	24,180.3	-	100%
3	80224-Зөвлөл хороо гишүүдийн санхүүжилт	2,500.0	1,678.9	821.1	67.1%
НИЙТ		1,489,424.3	1,487,166.7	2,257.6	83.5%

Үндсэн үйл ажиллагааны арга хэмжээний зардлын гүйцэтгэл 83.5 хувьтай хэрэгжсэн нь батлагдсан бүтэц орон тоо дутуугаас (1 орон тоо дутуу) цалин, нэмэгдэл урамшууллын зардал 2,257.6 мянган төгрөгөөр хэмнэгдэж дээд шатны төсөвт төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн ЗДНС-аас санхүүгийн дэмжлэгээр 20,000.0 мянган төгрөгийн орлого төвлөрч гүйцэтгэлээр 20,000.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансны зарцуулалтыг авч үзвэл урсгал засварын зардалд 9,840.0 мянга, бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний зардалд 10,160.0 мянган төгрөгийг тус тус зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөөгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар аймаг дахь Шүүхийн тамгын газар 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитор А.Мөнхцэцэг, гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Сүхбаатар аймаг дахь Шүүхийн тамгын газар 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 05/16 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нийт зардлын 1,145,276.6 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 22,905.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1¹, 15.2.3²-т зардлын хэмнэсэн эсэхийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулж үзэхэд уг зардлууд 233.3-129,353.7 мянган төгрөгөөр өссөн байна. Тухайлбал: Нэмэгдэл цалин 129,353.7 мянга, НДШ 28,591.0 мянга, түлш халаалт 23,904.9 мянга, тээвэр шатахуун 8,624.1 мянга, бичиг хэрэг 4,987.8 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Их засвар хийхтэй холбоотойгоор урсгал засварын зардлаас 44,254.4 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж 11,901.3

¹ байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх;

² сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх;

мянга, БҮТЭ зардлаас 1,100.0 мянга, шатахуун 3,000 мянга нийт 60,255.7 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Дээрх зардлууд өмнөх оноос нэмэгдсэн учир шалтгааныг авч үзвэл:

- Цалингийн нэмэгдэл, НДШ: Шүүгч нарын ажилласан жилийн болон онцгой нөхцөлийн нэмэгдэл, шүүгчийн туслах, нарийн бичгийн дарга нарын цалин нэмэгдсэн нь нөлөөлсөн.
- Түлш халаалтын зардал: Тухайн байгууллага халаалтын зардлыг тоолуурын заалтаар төлбөр төлөгддөг байсан. 2022 онд ЭХЗХ-ны 461-р тогтоолоор тарифын үнэ нэмэгдсэнээр сард дунджаар 3,500.0-5,000.0 мянган төгрөгийн төлбөр нэмж төлж байгаа нь нөлөөлсөн.
- Тээвэр шатахууны зардал: Шатах тослох материалын үнэ өмнөх оноос дунджаар 52.0 хувиар нэмэгдсэн нь гол нөлөөлөл үзүүлсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллийг хуулийн хугацаанд шилэн дансны цахим хуудсанд мэдээлсэн байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сүхбаатар аймгийн Шүүхийн тамгын газарт завсрын аудит хийгээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 3 Зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		/мянган төгрөгөөр/ Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	-	1	0	100%
Нийт дүн	1		1		

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 67,207.5 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 6,951.8 мянган төгрөгийн зөрчилд³ төлбөрийн акт тогтоож, 60,255.7 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага өгөв.

5.1 Төлбөрийн акт

- Батлагдсан төсвөөс ойн арга хэмжээнд танилцуулга бэлтгэх, бэлэг дурсгалын зүйлс флаш, сд зэргийг худалдан авахад 5,050.0 мянган төгрөг зарцуулсан
- Нормын хувцас, зөөлөн эдлэлийн зардлаас ажилчдад 800.0 мянган төгрөгийн хувцас авч, төсвийг үр ашиггүй зарцуулсан.
- Төсвөөс 784.0 мянган төгрөгийн бэлэг дурсгалын зүйл худалдан авч, төсвийг үр ашиггүй зарцуулсан
- Томилолтын зардлаас албан томилолтоор ажиллаж байгаа албан хаагчдад 317.8 мянган төгрөгийн хоол хүнсний материал худалдан авч төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1⁴, 41 дүгээр зүйлийн 41.2.3⁵, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3⁶, 12.1, 12.1.4⁷, 15 дугаар зүйлийн 15.1.5⁸-т заасныг зөрчсөнд төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

- Тайлант онд төсвийн хөрөнгөөр 22,525.7 мянга төгрөгийн машиныг зогсоол, 37,730.0 мянга төгрөгийн хашааны ажлыг барьж, гүйцэтгэхдээ худалдан авах ажиллагааг холбогдох хууль, тогтоолын дагуу зохион байгуулаагүй;
- Тээвэр шатахууны зарцуулалтыг жолоочийн тооцооны хуудсанд холбогдох зааврын дагуу үнэн зөв хөтөлж, ямар ажлаар хаашаа явсныг тодорхой бичиж толилуулаагүй зөрчил дутагдал илэрлээ.

³ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

⁴ төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;/

⁵ төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах

⁶ Албан томилолтоор ажиллаж байгаа албан хаагчийн тээврийн хэрэгсэл, байр, хоолны зардлыг албан томилолтоор ажиллуулсан байгууллага төсөвлөж олгосон тохиолдолд энэ хуулийн 3.1-д заасан байгууллага, албан тушаалтнаар төлүүлэхийг хориглоно

⁷ хуулиар зөвшөөрөөгүй бусад.

⁸ төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах;

Энэ нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1⁹, 19 дүгээр зүйлийн 19.1¹⁰, 33 дугаар зүйлийн 33.2.1¹¹, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3¹², Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар” журмын -ыг тус тус зөрчсөнд албан шаардлага хүргүүлээ.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Цалингийн сангийн хэмнэлтээс ахмадын санд төвлөрүүлсэн нь Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2017 оны 197 тоот тогтоолын холбогдох заалтуудтай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Ахмадын санд төвлөрүүлэх хөрөнгийг төсөвтөө төлөвлөж, зарцуулж байх

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/											
Зөрчлийн товч утга	Нийт зөрчил				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	
	Худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй байна.	1	60,255.7			1	60,255.7				
Тээвэр шатахууны зарцуулалтыг жолоочийн тооцооны хуудсанд холбогдох зааврын дагуу үнэн зөв хөтөлж, ямар ажлаар хаашаа явсныг тодорхой	1				1	-					

⁹ харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар

¹⁰ /Захиалагч тендерийн баримт бичгийг төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан тендерийн жишиг баримт бичиг, гэрээний маягт болон тендер шалгаруулалтад холбогдох бусад журам, аргачлалын дагуу бэлтгэнэ

¹¹ үнийн санал ирүүлэх урилгыг энэ хуулийн 52.1.12, 53.5.4-т заасан худалдан авах ажиллагааны цахим системд зарлаж, үр дүнг тухай бүрд мэдээлэх

¹² үр ашигтай байх

бичиж толилуулаагүй зөрчил дутагдал илэрлээ.										
800.0	1	800.0	1	800.0						
Бичиг хэрэг, БҮТЭЭ-ийн зардлаас ойн арга хэмжээнд 2,750,000 төгрөгийн танилцуулга, 2,300,000 төгрөгийн флаш сиди худалдан авч төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан.	1	5,050.0	1	5,050.0						
Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс зардлаас 783,952 төгрөгийн бэлэг дурсгалын зүйл худалдан авч, төсвийг үр ашиггүй зарцуулсан.	1	783.9	1	783.9						
Томилолтын зардлаас албан томилолтоор ажиллаж байгаа албан хаагчдад 317,800 төгрөгийн хоол хүнсний материал худалдан авч төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан.	1	317.8	1	317.8						
Цалингийн сангийн хэмнэлтээс ахмадын санд төвлөрүүлсэн нь Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2017 оны 197 тоот тогтоолын холбогдох заалтуудтай нийцээгүй байна.	1						1			
Дүн	7	67,207.5	4	6,951.8	2	60,255.7	1			